



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.08.19 № 679
танай _____ ны № _____ Т

**БУЛГАН АЙМГИЙН БУГАТ
СУМЫН СОНГУУЛИЙН ХОРООНД**

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн
талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Бугат сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Н.Намсрайгийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа,

006021366

мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч иргэн Н.Намсрай Бугат сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч иргэн Н.Намсрайгийн мөрийн хөтөлбөр (.....1.....хуудас)-ийг хавсаргав

Хувийг: Бие даан нэр дэвшигч иргэн Н.Намсрайд

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

БУЛГАН АЙМГИЙН БУГАТ СУМЫН 2024 ОНЫ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ НЯМСҮРЭНГИЙН НАМСРАЙГИЙН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Нэг.Нийгмийн талаар

- 1.1 Эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээг сайжруулах бодлогыг баримтлана.
- 1.2 Сум орон нутагт нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх бодлогыг дэмжинэ.
- 1.3 Багийн гэр цэцэрлэгийн үйл ажиллагааг тогтмолжуулах, сургуулийн өмнөх боловсролын чанар хүртээмжийг сайжруулах бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.4 Багийн хүүхдийн хамран сургалтыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.5 Залуу малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж улс, аймгийн хэмжээнд хэрэгжих томоохон төсөл хөтөлбөрүүдэд хамруулж шинээр ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг дэмжинэ.

Хоёр.Эдийн засаг, хөдөө аж ахуйн талаар

- 2.1 Малчдыг хоршооны үйл ажиллагаа эрхлэх, нөхцөл боломжийг бүрдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.2 Уламжлалт бэлчээрийн мал аж ахуйд малын төрөл хоорондын харьцаа, сүргийн зохистой бүтцийг бүрдүүлэх бодлогыг дэмжинэ.
- 2.3 Мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх бодлогыг дэмжинэ.
- 2.4 Өрхийн үйлдвэрлэл эрхлэх хүсэлтэй иргэдийг зээлийн хөтөлбөрт хамруулах замаар өрхийн амжиргааны төвшинг дээшлүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.5 Газар зохион байгуулалтын төлөвлөлт, газар ашиглалтыг сайжруулж, газрын зөрчлийг арилгах ажлыг бодлогоор дэмжинэ.
- 2.6 Сумын өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалтад иргэд хяналт тавих бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.7 Сумын хог хаягдлын цэгийн байршил, энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд технологийн шинэчлэл хийх бодлогыг дэмжинэ.
- 2.8 Орон нутгийн зам, гүүр, тэмдэг, тэмдэглэгээ, гэрэлтүүлгийн арчлалт, хамгаалалтыг сайжруулах бодлогыг хэрэгжүүлнэ.

МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН:



/Н.НАМСРАЙ/ 90988558, 95139786